

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР:

Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх

АУДИТЫН КОД: ХЭА/2020/06-НА

Чингис хот.

2021 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112. Цахим хаяг:
erdenebaatararch@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Туяа

Утас: 92116760 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
НА	Нийцлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХЭА	Хэнтий аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай
МАН	Монгол Ардын нам
АН	Ардчилсан нам
МАХН	Монгол Ардын хувьсгалт нам

АГУУЛГА		
Тайлан бэлтгэсэн: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Аудитын менежер: Д.Оюунтуяа Ахлах аудитор: Н.Туяа Д.Эрдэнэбилэг Аудитор Ц.Энхтүвшин Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймаг дахь Төрийн Аудитын газрын khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу. Хаяг: Хэнтий аймаг Чингис хот АЗДТГ-ын байр. 320 тоот өрөө 2021 оны 1 дүгээр сар	Ерөнхий зүйл	
	Аудит хийсэн үндэслэл	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ	3
	Арга зүй	3
	Шалгуур үзүүлэлт	3
	Үндсэн мэдээлэл үзүүлэлт	4
	БҮЛЭГ 1. НАМЫН 10 ХОРОО, 29 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНС НЭЭГЭЭГҮЙ, 23 НАМЫН ХОРОО, 125 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГАА АУДИТАД ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	5-6
	1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон намын 50 хувь, нэр дэвшигчдийн 14.6 хувь нь зардлын тайлангаа баталгаажуулж төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.	5
	1.2. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон намын 21.7 хувь, нэр дэвшигчдийн 3.4 хувь нь сонгуулийн зардлын данс нээгээгүй байна.	6
	БҮЛЭГ 2. НЭР ДЭВШИГЧДЭД ТӨВЛӨРСӨН ОРЛОГЫН 28.3 ХУВЬ НЬ СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХАНДИВЫН ОРЛОГО БАЙНА.	6-8
	2.1. Нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн шаардлагын дагуу бүрдүүлээгүй байна.	6
	2.2. Нэр дэвшигчид хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй 45.6 сая төгрөгийн хандивыг буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан байна.	7
	БҮЛЭГ 3. НАМ, НЭР ДЭВШИГЧИД ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТАЛСАН БАЙНА.	8-10
	3.1. Нам, нэр дэвшигчид нь хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулсан байна.	8
	3.2. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.	10
	Дөрөв. Дүгнэлт	11
	Тав. Тэргүүлэх аудиторовын тушаал	12
	Хавсралт 1. Нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт	
	Хавсралт 2. Намд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт	
	Хавсралт 3. Зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчид, намын жагсаалт	
	Хавсралт 4. Сонгуулийн зардлын данс нээгээгүй нэр дэвшигчид, намын жагсаалт	
	Хавсралт 5. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайлан	
	Хавсралт 6. Нэр дэвшигчдийн дансны хуулга ирүүлээгүй банкны жагсаалт	

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай” хуулийн 57.1 дэх заалтыг үндэслэн, “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийсэн. Үүнд:

- Нам, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа баталгаажуулж төрийн аудитын байгууллагад ирүүлсэн үү?
- Нам, нэр дэвшигч нь сонгуулийн санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлсэн үү?
- Нам, нэр дэвшигч нь хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулсан уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ-ын хурлын сонгуульд оролцсон МАН, АН, МАХН-ын 46 хороо, 857 нэр дэвшигчийг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4000 дугаар стандартууд, Төрийн аудитын тулгуур зарчим MNS6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, намын холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа авах, хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан зардлын тайланг харилцах дансны хуулгатай тулган баталгаажуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Тэргүүлэх аудиторовын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/25 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”, 2-р хавсралтаар баталсан “Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах маягтууд”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Д.Оюунтуяа үе

шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Туяа, Д.Эрдэнэбилэг, аудитор Ц.Энхтүвшин нар 2020 оны 12 дугаар сарын 01-ээс 2021 оны 1 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэлээ. Аудитын дүнг нийтэд мэдээлж, audit.mn-д байршууллаа.

Үндсэн мэдээлэл

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай” хуулийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан.

Аймгийн ИТХ-ын ээлжит сонгуулийн 26 тойрогт МАН-аас 39, АН-аас 38, МАХН-аас 4 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна. Нийт 18 сумын ИТХ-ын ээлжит сонгуульд МАН-аас 384, АН-аас 381, МАХН-аас 11 нэр дэвшигч оролцсон байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нийт 3 намын 46 хороо, 857 нэр дэвшигч оролцжээ.

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчийн тоо

№	Намын нэр	Намын тоо		Нэр дэвшигчид		Нийт
		Аймгийн ИТХ	Сумын ИТХ	Аймгийн ИТХ	Сумын ИТХ	
1	Монгол Ардын нам	1	18	39	384	442
2	Ардчилсан нам	1	18	38	381	438
3	Монгол Ардын Хувьсгалт нам	1	7	4	11	23
	Дүн	3	43	81	776	903

БҮЛЭГ 1. НАМЫН 10 ХОРОО, 29 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНС НЭЭГЭЭГҮЙ, 23 НАМЫН ХОРОО, 125 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГАА АУДИТАД ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон намын 50 хувь, нэр дэвшигчдийн 14.6 хувь нь зардлын тайлангаа баталгаажуулж төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

1.1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд МАН, АН, МАХН оролцсоноос АН-ын 19 хороо, аймаг, Хэрлэн сумын МАН-ын хороо, аймгийн МАХН-ын түмт сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн намын хороо

№	Намын нэр	Намын хороо тоо		Тайлан ирүүлсэн		Тайлан ирүүлээгүй
		Аймгийн ИТХ	Сумын ИТХ	Аймгийн ИТХ	Сумын ИТХ	
1	Монгол Ардын нам	1	18	1	1	17
2	Ардчилсан нам	1	18	1	18	0
3	Монгол Ардын Хувьсгалт нам	1	7	1	1	6
	Дүн	3	43	3	20	23

МАН-ын 17 сумын хороо, МАХН-ын 6 сумын хороо сонгуулийн зардлын тайлангаа баталгаажуулж ирүүлээгүй нь АНСДИТХСТ хуулийн 56.3¹ дахь заалтыг зөрчсөн байна. /Хавсралт 3/

1.1.2. Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон МАН-ын 308, АН-ын 381, МАХН-ын 3, нийт 732 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн нэр дэвшигчийн тоо

№	Намын нэр	Нэр дэвшигчдийн тоо		Тайлан ирүүлсэн		Тайлан ирүүлээгүй
		Аймгийн ИТХ	Сумын ИТХ	Аймгийн ИТХ	Сумын ИТХ	
1	Монгол Ардын нам	39	384	39	308	76
2	Ардчилсан нам	38	381	37	345	37
3	Монгол Ардын Хувьсгалт нам	4	11	2	1	12
	Дүн	81	776	78	654	125

¹ “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.”

МАН-ын 76, АН-ын 37, МАХН-ын 12, нийт 125 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа гаргаж ирүүлээгүй нь АНСДИТХСТ хуулийн 56.3 дахь гэсэн заалтыг зөрчсөн байна. /Хавсралт 3 /

Зардлын тайлан ирүүлээгүй дээрх зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25² дахь заалтын дагуу шийдвэрлүүлэхээр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлээ.

Нам, нэр дэвшигч нарын сонгуулийн зардлын тайланд Өндөрхаан-Итгэл аудит ХХК, Ниямазон аудит ХХК, Ай Жэй Эй Эйч- Аудит ХХК, Эвиденсе аудит ХХК, Өлзий экаунт ХХК, Уваа Уул аудит ХХК -иуд дүгнэлт гаргаж ирүүлснээс намын зардлын тайланд “Зөрчилгүй” 15, “Хязгаарлалттай” 7 дүгнэлтийг , нэр дэвшигчдийн зардлын тайланд “Зөрчилгүй” 672, “Хязгаарлалттай” 60 дүгнэлтийг тус тус гаргасан байна.

1.2. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон намын 21.7 хувь, нэр дэвшигчдийн 3.4 хувь нь сонгуулийн зардлын данс нээгээгүй байна.

Сонгуульд оролцсон МАН-ын 7 сумын хороо, МАХН-ын 3 сумын хороо болон нэр дэвшигчдээс АН-ын 19, МАХН-ын 10, нийт 29 нэр дэвшигч банканд сонгуулийн зардлын данс нээлгээгүй нь АНСДИТХСТ хуулийн 50.1³, 50.2⁴, 50.3⁵ дахь гэсэн заалтуудыг зөрчсөн байна. /Хавсралт 4 /

Энэхүү зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21⁶ дахь заалтын дагуу шийдвэрлүүлэхээр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

БҮЛЭГ 2. НЭР ДЭВШИГЧДЭД ТӨВЛӨРСӨН ОРЛОГЫН 28.3 ХУВЬ НЬ СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХАНДИВЫН ОРЛОГО БАЙНА.

2.1. Нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн шаардлагын дагуу бүрдүүлээгүй байна.

2.1.1. Аймгийн МАН-ын хороонд 30.0 сая төгрөг, АН-ын хороонд 31.5 сая төгрөгийн, нийт 61.5 сая төгрөгийн санхүүжилтийг намын төв байгууллагаас оруулсан бол МАН-д 13 иргэнээс 20.7 сая төгрөгийн, АН-д 13 иргэнээс 1.3 сая төгрөгийн, нийт 22.0 сая төгрөгийн хандивын орлого орсон ба АН 4.0 сая

² “ Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

³ “Нам, эвсэл тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

⁴ “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.”

⁵ “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.”

⁶ “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”

төгрөгийн хөрөнгийг өөрөө төвлөрүүлсэн байна. МАХН хөрөнгө огт төвлөрүүлээгүй байна.

Намын орлого /сая төгрөг/

№	Нам	Нийт орлого	Намаас оруулсан хөрөнгө		Өөрийн хөрөнгө		Хандивын орлого			
			Намын хороо	дүн	Намын хороо	дүн	Иргэн		Хуулийн этгээд	
1	МАН	50.7	1	30.0			2	20.7		
2	АН	36.8	14	31.5	10	4.0	4	1.3		
3	МАХН	0.0								
	Дүн	87.5	15	61.5	10	4.0	6	22.0	0	-

2.1.2. Нэр дэвшигчдийн тайланг нэгтгэхэд иргэнээс 257.6 сая төгрөгийн, хуулийн этгээдээс 26.7 сая төгрөгийн төгрөгийн хандивын орлого, 1.5 сая төгрөгийн намын дэмжлэгийн орлого орж, 66.3 сая төгрөгийн хөрөнгийг өөрөө төвлөрүүлсэн байна. Нийт орлогыг дараах байдлаар харуулбал:

Нэр дэвшигчдийн орлого / сая төгрөг/

№	Нам, нэр дэвшигч	Нийт орлого	Намын хөрөнгө		Өөрийн хөрөнгө		Хандивын орлого			
			Нэр дэвшигч тоо	дүн	Нэр дэвшигч тоо	дүн	Иргэн		Хуулийн этгээд	
							Нэр дэвшигч тоо	дүн	Нэр дэвшигч тоо	дүн
1	Нэр дэвшигч /МАН/	248.0			259	38.6	242	186.7	21	22.7
2	Нэр дэвшигч /АН/	103.4	2	1.5	311	27.7	189	70.2	3	4.0
3	Нэр дэвшигч /МАХН/	0.7			2	0.0	3	0.7		
	Дүн	352.1	2	1.5	572	66.3	434	257.6	24	26.7

Иргэн, хуулийн этгээдийн өгсөн хандивыг сонгуулийн зардлын тайлан, дансны хуулгатай тулган шалгахад нэр дэвшигчийн 284.3 сая төгрөгийн хандивын орлогын 99.6 сая төгрөг буюу 35 хувь нь нэр, регистрийн дугааргүй, эх үүсвэр тодорхойгүй, тогтоосон хэмжээнээс илүү байгаа нь хуулийн шаардлагад нийцэхгүй байна.

2.2. Нэр дэвшигчид хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй 46.6 сая төгрөгийн хандивыг буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан байна.

Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандив

Нэр дэвшигчид нийт 99.6 сая төгрөгийн хандиваас 49.0 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлсэн бол 385 иргэнээс өгсөн 46.6 сая төгрөгийн хандивыг буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан байна. Энэ нь АНСДИТХСТ хуулийн 53.4, 55.2, 55.3. дахь заалтыг зөрчсөн байна. / хавсралт 5 /

Үүнээс АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх “Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна.” заалтад нийцээгүй 5.4 сая төгрөгийн 2 иргэнээс өгсөн хандивыг авч зарцуулсан байна. /Хавсралт 5 /

Дээрх хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй 46.6 сая төгрөгийн хандивыг зарцуулсан нэр дэвшигчийн жагсаалтыг гаргаж АНСДИТХСТ хуулийн 55.4⁷ дэх, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23⁸, 22⁹ дахь заалтын дагуу шийдвэрлүүлэхээр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлээ.

АНСДИТХСТ хуулийн 57.1 дэх заалтын дагуу 2020 оны аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 69.5 сая төгрөгийн хандив өгсөн 51 иргэн, нэр дэвшигчид хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн 22.0 сая төгрөгийн хандив өгсөн 5 хуулийн этгээдийн жагсаалтыг хавсралтаар мэдээлж байна. / Хавсралт 1 /

АНСДИТХСТ хуулийн 57.1 дэх заалтын дагуу 2020 оны аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон намд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 20.2 сая төгрөгийн хандив өгсөн 11 иргэний жагсаалтыг хавсралтаар мэдээлж байна. /Хавсралт 2/

Намд хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

БҮЛЭГ 3. НАМ, НЭР ДЭВШИГЧИД ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТАЛСАН БАЙНА.

3.1. Нам, нэр дэвшигчид нь хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулсан байна.

3.1.1. Нам сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 85.1 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд: МАН 50.7 сая төгрөгийн, АН 34.4 сая төгрөгийг зарцуулж, МАХН огт зардал гаргаагүй байна. Зардлыг нам тус бүрээр харуулбал:

Намын сонгуулийн зардал /сая төгрөг/

№	Зардлын ангилал	Нийт дүн	Үүнээс:		
			МАН	АН	МАХН
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	31.8	25.2	6.6	-
2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгаа байрлуулах	0.7	0.1	0.6	-

⁷ “Энэ хуулийн 55.2-т заасныг зөрчиж хүлээн авсан хандивыг улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.”

⁸ “Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

⁹ “Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**ХЭА-2020/06/-НА**

3	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	2.2	1.2	1	-
4	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	16.5	6.5	10	-
5	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	1.3	0.3	1	-
6	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	9.4		9.4	-
7	Цахим орчин ашиглах зардал	17.0	17.0		-
8	Бусад зардал	6.2	0.4	5.8	-
	Дүн	85.1	50.7	34.4	0

Намууд сонгуулийн үйл ажиллагааны зардалд 78.9 сая төгрөг, бусад зардалд 6.2 сая төгрөгийг зарцуулж, хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль журмыг мөрдсөн байна. Намуудад сонгуулийн зардлын өглөгийн үлдэгдэл байхгүй байна.

3.1.2. Нэр дэвшигчид хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан байна.

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 342.7 сая төгрөгийг зарцуулснаас сонгуулийн зардалд 264.0 сая, бусад зардалд 78.7 сая төгрөгийг зарцуулжээ. Нэр дэвшигчдийн зардлыг нам, зардлын ангиллаар харуулбал:

Нэр дэвшигчдийн зардал /сая төгрөг/

№	Зардлын ангилал	Нийт дүн	Үүнээс:		
			МАН	АН	МАХН
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	70.6	49.6	21.0	0.0
2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгаа байрлуулах	2.4	2.0	0.4	0
3	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	5.9	2.4	3.5	0
4	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	169.8	127.7	41.5	0.6
5	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	1.4	1.0	0.4	0
6	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	10.4	3.2	7.2	0
7	Цахим орчин ашиглах зардал	3.4	2.4	1.0	0.01
8	Бусад зардал	78.7	51.7	27.0	0.04
	Дүн	342.7	240.0	102.0	0.7

Тайлан ирүүлсэн нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хууль журамд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянахад батлагдсан маягтын дагуу бүрэн гаргаагүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, анхан шатны

баримтаар нотлогдоогүй, тайланг зөрүүтэй гаргасан зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

3.2. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Аймгийн МАН-ын хороо 50.7 сая, аймгийн АН-ын хороо 16.0 сая төгрөгийн, сумдын намын хороо 3.0- 0.001 сая зардал гаргасан нь АНСДИТХСТ хуулийн 49.1 дэх заалтын дагуу Төрийн аудитын байгууллагаас аймгийн намын хороо 482.6 сая, сумын намын хороо 13.4-38.6 сая төгрөг хүртэл зардал гаргахаар тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Нэр дэвшигчид 0-18.2 сая төгрөгийн зардал гаргасан нь төрийн аудитын байгууллагаас аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчид 14.6- 59.8 сая, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчид 12.0-27.4 сая төгрөг хүртэл зардал гаргахаар тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Зардлын хэмжээг авч үзвэл 1.0 – 18.2 сая төгрөг хүртэл зардал гаргасан 83 нэр дэвшигч, 0.002-1.0 сая хүртэл зардал гаргасан 541 нэр дэвшигч, огт зардал гаргаагүй 108 нэр дэвшигч байна.

АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.5¹⁰ -д заасны дагуу ХААН банк, Төрийн банкнаас нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн боловч ХААН банк 33, Төрийн банк 2 нэр дэвшигчийн дансны хуулгыг ирүүлээгүй байна. Үүнд: Өмнөдэлгэр сумын 7, Биндэр сумын 1, Норовлин сумын 2, Батноров сумын 20, Мөрөн сумын 4, Хэрлэн сумын 1 нийт 35 нэр дэвшигчийн сонгуулийн дансны хуулгыг ирүүлээгүй байна. / Хавсралт 6/

¹⁰ “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн 16.4 хувь нь сонгуулийн зардлын тайланг аудитын байгууллагад ирүүлээгүй байна.
2. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн 4.3 хувь нь сонгуулийн зардлын данс нээгээгүй байна.
3. Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам 87.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн 85.1 сая төгрөгийг зарцуулж, нэр дэвшигчид 352.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн 342.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
4. Нэр дэвшигчид хандивын эх үүсвэр, хандив өгсөн иргэний нэр, регистрийн дугаар тодорхойгүй, хуулийн шаардлага хангаагүй 46.6 сая төгрөгийн хандивыг 385 иргэнээс өгснийг хуулийн дагуу буцаан төвлөрүүлээгүй зарцуулсан байна.
5. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна.

Аудитаар АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь *“сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх”* бүрэн эрхийн хүрээнд сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй, сонгуулийн зардлын данс нээгээгүй нам, нэр дэвшигчдийн, хуулийн шаардлага хангаагүй хандивыг буцаан төвлөрүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалтыг хавсралтаар гаргаж, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21,22,23,25 дугаар зүйлийн дагуу шийдвэрлүүлэхээр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлээ.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ


**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2021 оны 01 дугаар сарын 12 Дугаар 1/01 Чингис хот

Г Нийцлийн аудитын тайлан Т
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон намд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэн ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
5. "Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх" аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг 3,4,5,6 дугаар хавсралтаар баталсугай.
6. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР



023010002